

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилго: Сумын Засаг даргын Тамгын газрын авилгалын эсрэг урьдчилан сэргийлэх , соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх

2022.11.04

“Онгон”

Д.д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	
1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт				
1	1.1 Сумын ИТХ, Засаг даргаас гаргах шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо нөхцөлөөр хангах	1.1.1 Сумын ИТХ, Засаг даргын шийдвэрийн төслүүдийн талаар иргэд олон нийтээс санал авах, тусгах, эргэж мэдээлдэг механизм бүрдүүлэх/ цахим хуудас, санал асуулга, саналын хайрцаг, утсаар авч эргэж мэдээлэг болох/ 1.1.2 Орон нутгийн тухай жилийн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх батлах, ОНХ-ын сангийн хөрөнгөөр хийх ажлуудын саналыг авах зэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төсөв, худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах санал, хүүхдийн тоглоомын талбай барих газрын санал, засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловрсуулах зэрэгт сумын пейж хуудас, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдээс саналыг авч тусгасан. ОНХ-ын сангийн хөрөнгөөр 2023 онд хийх төсөл, хөтөлбөр, ажил, арга хэмжээнүүдэд 1001 иргэдээс санал авсан байна. 2022 оны худалдан авалтын төлөвлөгөөнд 3 ажлыг цахимаар зарлана гэж тусган tender.gov.mn-сайтаар цахимаар тендер зарлан зохион байгуулан ажиллаа	100 70
2	1.2 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	1.2.1 “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль тогтоомжийг сурталчлах / сумын сонинд булантай болох, мэдээллийн самбар ажиллуулах,	Байгууллагын дарга нар болон Тамгын газрын албан хаагчдад Авилга ашиг сонирхолын зөрчил, авилгаас урьдчилан сэргийлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудаар 25 албан хаагчдад сургалт танхимаар зохион байгуулсан. Мөн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалт ХАСХОМ гаргадаг болон, шинээр томилогдсон 10 албан хаагч хамрагдсан байна.	100

		1.2.2. Байгууллагын ил тод байдлын самбарын мэдээллийг тогтмол шинэчлэх	Байгууллагын ил тод байдлын самбарын мэдээллээ тогтмол шинэчлэж байна.	100
3	1.3 Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	1.3.1 Сумын ИТХ,Засаг даргаас 2022 онд хэлэлцүүлж гаргахаар шийдвэрлэсэн бодлогын баримт бичигт олон нийтийн саналыг тусгахаар хэлэлцүүлэг, уулзалтыг иргэд олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж, бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх	“Сумын төвийн дүрэм” гэсэн баримт бичиг батлуулахаар төслийг нь боловсруулж төсвийн байгууллагуудын албан хаагчдаар хэлэлцүүлсэн, мөн 5 дугаар багийн иргэдээр хэлэлцүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна.	100
4	1.4 Байгууллагын хяналт шалгалтын үйл ажиллагааны ил, тод нээлттэй байдлыг хангах, үр дүнг нээлттэй мэдээлэх	1.4.1 Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас явуулсан хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2022 онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй.	100
		1.4.2 Аудитын газраас явуулсан хяналт, шалгалтын мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх	Аудитын газарт 2021 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж зөрчилгүй дүгнэлт авсан. Мөн аймгийн аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Аймгийн аудитын газраас Төлбөр барагдуулах тухай акт, зөрчил арилгах тухай албан шаардлага 2 тус тус ирсэн. Акт албан шаардлагын хариуг мэдээлэлх хугацаа болоогүй байна. Шалгалтын мэдээллийг иргэдэд нээлттэй мэдээлэх зорилгоор мэдээллийн самбарт байршуулсан.	100
5	1.5 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад дотоодын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлж байх	1.5.1 Тухайн жилийн төсөв/1-р сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэл 4-р сарын 1-ний дотор, дараа жилийн төсвийн төсөл 8-р сарын 15-ны дотор shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан байх/	Бүх байгууллагууд Тухайн жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэл 4-р сарын 1-ний дотор, дараа жилийн төсвийн төсөл 8-р сарын 15-ны дотор shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж хэвшсэн	100

	1.5.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Төсвийн бүх байгууллагууд жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан	100
	1.5.3 Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Төсөвт орсон өөрчлөлтийг shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан	100
	1.5.4 Төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Төсвийн орлого бүрдүүлэлтийн сар улирлын мэдээг shilendans.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	100
	1.5.5 Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг мэдээллийн самбарт байршуулах	1 цонхны үйлчилгээ” ил тод нээлттэй байдлын самбарт нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байгаа иргэдийн мэдээллийг тогтмол байршуулж байна.	100
	1.5.6 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг shilendans.gov.mn цахим хуудас болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж сурталчлах	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг shilendans.gov.mn burd.gov.mn байгууллагын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100
	1.5.7 Орон нутгийн хөгжлийн сангийн болон улс аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас байгуулсан ажлын хэсэг 2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад 2 удаа хяналт хийсэн. Хяналт хийсэн тухай тайланг ИТХ-аар хэлэлцүүлж, Засаг даргад	100

		хөтөлбөрт тавих иргэдийн хяналтыг сайжруулах	анхаарах асуудлаар албан тоот хүргүүлсэн байгаа.	
		1.5.8 СХСан зэрэг улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа зээлийн хэрэгжилт, зарцуулалтанд иргэд олон нийтийн оролцоотой мониторинг хийж , дүгнэлт зөвлөмж гарган хариуцлага тооцон ажиллах	ИТХ-аар хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг баталсан. Зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 1 иргэний төлөөлөл орсон. 2020 он, 2021 он , 2022 онуудад зээл олголт байхгүй бөгөөд 2021 онд Өвөрхангай аймгийн засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүү дотоод аудитын шалгалт, 2022 онд тус газраас зээлдэгчдийн ажлын байр, зээлийн төслийн хэрэгжилтийн шалгалт тус тус хийгдсэн. Шалгалтын мөрөөр зөрчил дутагдлыг арилган нийт 3 иргэний 42370698 төгрөгний хэргийг шүүхийн байгууллагад, 1 иргэний 3845380 төгрөгний хэргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд, тоног төхөөрөмжийн маргаантай 2 иргэний 2658616 төгрөгний асуудлыг дээд шатны байгууллагад мэдэгдээд байна.	70
6	1.6 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	1.6.1 Төрийн албаны сул орон тооны зарыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах	Тус сумын ЗДТГ-т сул орон тоо байгаа бөгөөд аймгийн төрийн албаны зөвлөлд захиалга хүргүүлсэн. Аймгийн төрийн албаны зөвлөлөөс зарласан сонгон шалгаруулалтыг сумын пейж хуудас олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлж байна. Сумын ЗДТГ-ын орон тоог баталсан аймгийн засаг даргын захирамжийг сумын веб сайтад байршуулсан.	100
		1.6.2 Албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэх дүрэм, журам зааврыг цахим хуудсанд байршуулах	Албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэх дүрэм, журам зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	100
		1.6.3 Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийн	Сумын засаг даргын захирамжаар байгууллагын дарга, санхүүгийн албаны даргын, байгууллагын даргын тушаалаар бусад албан хаагчдын албан	100

		талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах	тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлан цахим сайтад мэдээлсэн.	
7	1.8 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авилгатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	1.7.1 Эрх бүхий албан тушаалтанг томилж , авилга, ашиг сонирхлын зөрчил, авилгын чиглэлээр гүйцэтгэх чиг үүргийг албан тушаалын тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусган хариуцлагыг нэмэгдүүлэх	ЗДТГ-ын дарга, байгууллагын дарга, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтонд , авилга, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх, авилгын чиглэлээр гүйцэтгэх чиг үүргийг тусгасан. Мөн томилж байгаа шийдвэрт ХАСХОМ-ыг 30 хоногт гаргахыг холбогдох албан тушаалтануудад үүрэг болгосон.	100
		1.7.2 Төрийн албан хаагчдыг Авилгын эсрэг мэдээлэл аргазүйн зөвлөмжөөр ханган ажиллах	Албан хаагчдыг арга зүйн зөвлөмжөөр ханган хуульд заасан чиглэлүүдээр ажлын хэсэгт ороход мэдэгдэл тайлбарыг тогтмол авч веб сайтад шивж байна. АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтанд 12 албан хаагчийг оролцуулсан.	100
8	1.8 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхталаар ёс зүйн дүрмэнд нэмэлт оруулан мөрдүүлэх	1.8.1 Төрийн албан хаагчидтай ёс зүй хариуцлагын гэрээ байгуулах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлж тайлагнах	ЗДТГ-ын албан хаагчидтай ёс зүй хариуцлагын гэрээ байгуулж ажиллаж байна. Шинээр орж ирсэн албан хаагчдаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг заавал судлуулдаг.	100
		1.8.2 Байгууллагын ёс зүйн хорооны төлөвлөгөөг батлан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах	ЗДТГ ёс зүйн хороо төлөвлөгөө гарган ажиллаж байна . Ёс зүйн хороо 5 ажил зохион байгуулсан байна.	100
		1.8.3 Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд тухайн албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх, зөрчлийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг ажлыг тогтмолжуулж,	ийм зөрчил үүсээгүй	100

		урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах		
9	1.9 Байгууллагын удирдлагуудаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	1.9.1 Эрх бүхий албан тушаалтнаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг нээлттэй байлгах	Эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрүүдийг иргэдэд танилцах бололцоогоор хангаж байна.	70
		1.9.2 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах	Төлбөр хураамжийн жагсаалтыг ил тод байдлын самбар, сумын сайтан дээр байршуулж байна.	100
10	1.10 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	1.10.1 Өргөдөл санал, гомдол, хүсэлт, мэдээллийг шуурхай хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Тус байгууллагад 2022 оны 3-р улирлын байдлаар р нийт 537 өргөдөл ирснээс хуулийн хугацаанд 532 өргөдлийг шийдвэрлэж , 5 өргөдлийг дээд шатны байгууллагад шилжүүлсэн байна.	100
		1.10.2 Өргөдөл, гомдол, бичиг хэргийн асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Байгууллага бүр өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан харилцах утасыг мэдээллийн самбар дээр байршуулсан байгаа	100
		1.10.3 Иргэдийн өргөдөл санал, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, шуурхай шийдвэрлэн, хариуг сумын сонин , мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх	Өргөдөл гомдлын мэдээг сумын ил тод байдлын самбар болон сайтад мэдээлж байна.	100

		1.10.4 Суманд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх асуудлаар гаргасан иргэдийн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдээс egazar.gov.mn сайтаар болон бичгээр иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч сумын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулан багийн иргэдийн нийтийн хурал болон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийн санд нэгж талбар тус бүрээр нэр, байршилыг оруулдаг. Иргэд egazargov.mn сайтаар нэвтрэн сумын тухайн жилд олгохоор батлагдсан газрыг байршил, нэр тус бүрээр товч бөгөөд тодорхой харж хяналт тавих боломжтой болсон.	100
11	1.11. Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.	1.11.1 Сумын төсөвт байгууллагуудын байранд түүний үйлчилгээг эрхлэдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлуулахгүй байх	Тус байгууллагат гадны байгууллага байрлаагүй байгаа.	100
2. Авилгатай тэмцэх санал, санаачилга				
12	2.1. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	2.1.1 Байгууллагуудын менежментийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн менежментийг сайжруулах	Энэ чиглэлээр ЗДТГ гарын хурууны хээгээр цаг бүртгэн ажлын цагийн ашиглалтыг сайжруулах ажлыг хийж байна. Ажил тасалсан албан хаагчидтай хариуцлаа тооцон ажиллаж байна.	100

		<p>2.1.2 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдэх, хамтран ажиллах</p>	<p>АТГ-ын “Олон нийтийн төв”-ийн Өнөөдөр “ашиг” олж байгаа мэт санагдавч #авлигын хор уршгийг бүх нийтээрээ төлдөг...</p> <p>Бусдын #боломжийг бүү хулгайл !, Авлигаас хэн ч хождоггүй..., Үнэний ҮНЭ үгүй болсон энэ цагт</p> <p>Үүргээ ухамсарлан ТА шүглээ ҮЛЭЭ... #110 #ШүглээҮлээ #ИлчилжАВАР зэрэг контентууд, 10 дугаар сарын 11-ны мэдээлэл, #Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа #110 #Гомдол мэдээлэл хүлээн авах утас, #Зөв зөвд шударга зөв зурагт хуудас болон бусад мэдээллийг Өвөрхангай аймгийн Бүрд сумын албан ёсны пейж хуудсаар дамжуулан нийтэд тогтмол мэдээлдэг. Нийт 15 мэдээллийг хуваалцаж хүмүүст хүргэсэн байна.</p>	100
Бүгд оноо			96,7	

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Б.ГАЧМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

М.МӨНХБАЯР